



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
СТАТИСТИКИЙН  
ХЭЛТЭС



2026 IV

# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



# АГУУЛГА

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, дүүргээр		3
I	 ЭРҮҮЛ МЭНД	5
II	 ТӨСӨВ	9
III	 НИЙГМИЙН ДААТГАЛ	13
IV	 НИЙГМИЙН ХАЛАМЖ	16
V	 ГЭМТ ХЭРЭГ	19
VI	 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	25
VII	 ХӨДӨӨ АЖ АХУЙ	29
ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ		30

**I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.**

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

**II. Дараах тэмдэглэгээг ашиглав.**

- гүйцэтгэл байхгүй
- \* урьдчилсан гүйцэтгэл
- \*\* дахин
- <sup>1</sup> товчилсон үгийн тайлбар

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



МЭДЭЭЛЭЛ



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ

**ХҮСНЭГТ 1. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 IV	2023 IV	2024 IV	2025 IV	2026 IV	
Шинээр төрсөн хүүхэд	Хүн	10 199 <sup>↓162</sup>	11 580 <sup>↑135</sup>	10 347 <sup>↓106</sup>	9 657 <sup>↓67</sup>	9 690 <sup>↓03</sup>	
Халдварт өвчнөөр өвчлөгчид	Хүн	145 134 <sup>↑7.1**</sup>	6 179 <sup>↓95.7</sup>	5 972 <sup>↓3.4</sup>	7 147 <sup>↑19.7</sup>	8 352 <sup>↑16.9</sup>	
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	9 746 <sup>↑20**</sup>	9 678 <sup>↓0.7</sup>	9 058 <sup>↓6.3</sup>	13 119 <sup>↑44.8</sup>	13 818 <sup>↓5.3</sup>	
Хэрэглээний үнийн индекс, (жилийн өөрчлөлт)	Хувь	2.9 <sup>↓0.5</sup>	1.4 <sup>↓1.5</sup>	0.6 <sup>↓0.8</sup>	0.3 <sup>↓0.3</sup>	3.0 <sup>↑2.7</sup>	
Доллар (АНУ)	3 042 <sup>↑6.7</sup>	3 496 <sup>↑14.9</sup>	3 377 <sup>↓3.4</sup>	3 542 <sup>↑4.9</sup>	3 574 <sup>↑0.9</sup>	3 561 <sup>↑3.8</sup>	
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Юань (БНХАУ)	473 <sup>↑8.2</sup>	508 <sup>↑7.4</sup>	466 <sup>↓8.3</sup>	485 <sup>↑4.1</sup>	523 <sup>↑7.8</sup>	511 <sup>↑8.7</sup>
	Рубль (ОХУ)	38	43 <sup>↑13.2</sup>	36 <sup>↓16.3</sup>	43 <sup>↑19.4</sup>	47 <sup>↑9.3</sup>	46 <sup>↑35.3</sup>
Нийслэлийн төсвийн орлого	Тэрбум төгрөг	423.2 <sup>↑25.7</sup>	613.4 <sup>↑44.9</sup>	958.3 <sup>↑56.2</sup>	1 137.8 <sup>↑18.7</sup>	1 243.2 <sup>↑9.3</sup>	
Нийслэлийн төсвийн зарлага	Тэрбум төгрөг	354.6 <sup>↑7.9</sup>	539.5 <sup>↑52.1</sup>	718.4 <sup>↑33.2</sup>	1 363.8 <sup>↑89.8</sup>	606.2 <sup>↑17.8</sup>	
Агаарын дундаж температур	°C	3.4	0	4.9	4.7	3.7	

\* Дахин их

**ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр**

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 I-IV						2026 I-IV					
		Хотын дундаж	Хамгийн өндөр			Хамгийн бага			Хотын дундаж	Хамгийн өндөр			Хамгийн бага
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	357	Баянгол	8 797	Налайх	59	357	Баянгол	8 797	Налайх	59		
			Чингэлтэй	1 490	Багануур	47		Чингэлтэй	1 490	Багануур	47		
			Сүхбаатар	688	Багахангай	32		Сүхбаатар	688	Багахангай	32		
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	16	Багануур	29	Баянзүрх	10	15	Багануур	37	Хан-Уул	9		
			Сүхбаатар	17	Чингэлтэй	9		Налайх	23	Баянгол	6		
			Налайх	18	Багахангай	-		Сүхбаатар	14	Багахангай	-		
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	43	Багануур	42	Хан-Уул	26	50	Багануур	49	Сүхбаатар	31		
			Баянзүрх	39	Налайх	18		Баянзүрх	48	Налайх	25		
			Баянгол	34	Багахангай	13		Чингэлтэй	38	Багахангай	5		
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	83	Баянзүрх	123	Баянгол	91	77	Баянзүрх	191	Налайх	86		
			Сүхбаатар	121	Багахангай	80		Хан-Уул	175	Багахангай	58		
			Хан-Уул	120	Багануур	26		Чингэлтэй	119	Багануур	25		
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	119	Сүхбаатар	200	Сонгино-хайрхан	78	125	Сүхбаатар	213	Багануур	69		
			Чингэлтэй	140	Налайх	41		Чингэлтэй	175	Багахангай	45		
			Баянгол	133	Баганхангай	29		Баянгол	142	Налайх	40		



## ЭРҮҮЛ МЭНД 2026 оны эхний IV сард

ᠮᠠᠨᠢᠵᠡ  
ᠬᠡᠮᠡᠨᠳᠡ

Амаржсан эх



2025 IV 1715

2026 IV 1649

3.8%



Шинээр төрсөн хүүхэд

2025 IV 1724

2026 IV 1679

2.8%



Нийт халдварт өвчнөөр өвчлөгсөд



2025 IV 986

2026 IV 1246

26.4%



0-1 насны хүүхдийн  
эндэгдэл

2025 IV 26

2026 IV 22

1-5 насны хүүхдийн  
эндэгдэл

2025 IV 3

2026 IV 3



# ЭРҮҮЛ МЭНД

**Дүүргийн хэмжээнд 2026 оны эхний IV сард 1246 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 260 (26.4%) хүнээр өссөн байна.**

Дүүргийн хэмжээнд 2026 оны 4 дүгээр сарын байдлаар 1246 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 260 (26.4%) хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 17.7 (94.1%) хүнээр өссөн байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 64 (5.1%) цусан суулга, 45 (3.6%) улаан эсэргэнэ, 12 (1%) гепатит, 158 (12.7%) салхин цэцэг, 4 (0.3%) гахайн хавдар, 14 (1.1%) сальмонеллэз, 6 (0.5%) ёлом, 287 (23%) гар хөл, амны өвчин, 115 (9.2%) улаанбурхан, 11(0.9%) хоолны хордлого, 26 (2.1%) эритема B08.3, 111 (8.9%) тэмбүү, 53 (4.3%) заг хүйтэн, 104 (8.3%) шинээр илэрсэн сүрьеэ, 83 (6.6%) трихомониаз, 60 (4.8%) B34.1

энтеровируст халдвар, 93 (7.6%) бусад халдварт өвчлөгчид тус тус эзэлж байна. Халдварт өвчнийг өмнөх онтой харьцуулахад салхинцэцэг 98 (38.3%), ёлом 7 (53.8%), хоолны хордлого 35 (76.1%), тэмбүү 39 (26%), заг хүйтэн 39 (42.4%), трихомониаз 18 (17.8%) тус тус буурсан байна. Харин цусан суулга 21 (48.8%), улаан эсэргэнэ 25 (2.2 дахин), ГХА өвчин 254 (8.7 дахин), эритема B08.3 3 (13%), гепатит 3 (33.3%), улаан бурхан 23 (25%), сальмонеллэз 4 (40%) тус тус өссөн байна.


### ХҮСНЭГТ 3. ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	Өсөлт, бууралт 2026/2025	
					тоо/нэгж	хувь
<b>НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН</b>	<b>Бодит тоо</b>	<b>819</b>	<b>986</b>	<b>1246</b>	<b>260</b>	<b>26.4</b>
<b>Үүнээс цочмог халдварт өвчин</b>	<b>Бодит тоо</b>	<b>441</b>	<b>551</b>	<b>806</b>	<b>255</b>	<b>46.3</b>
Цусан суулга	Бодит тоо	77	43	64	21	48.8
Улаан эсэргэнэ	Бодит тоо	32	20	45	25	2.2**
Менингит	Бодит тоо	0	0	0	0	0
Гепатит	Бодит тоо	7	9	12	3	33.3
Салхинцэцэг	Бодит тоо	219	256	158	-98	-38.3
Гахайн хавдар	Бодит тоо	19	2	4	2	100.0
Сальмонеллэз	Бодит тоо	10	10	14	4	40.0
Ёлом	Бодит тоо	9	13	6	-7	-53.8
ГХА өвчин	Бодит тоо	64	33	287	254	8.7**
Улаан бурхан	Бодит тоо	0	92	115	23	25.0
Хоолны хордлого	Бодит тоо	4	46	11	-35	-76.1
Эритема B08.3	Бодит тоо	0	23	26	3	13.0
Тэмбүү	Бодит тоо	134	150	111	-39	-26.0
Заг хүйтэн	Бодит тоо	63	92	53	-39	-42.4
Шинэ илэрсэн сүрьеэ	Бодит тоо	94	92	104	12	13.0
Трихомониаз	Бодит тоо	87	101	83	-18	-17.8

V34.1 Энтеровируст халдвар Бодит тоо 0 0 60 60 0

\*\*дахин их

**ЗУРАГ 1. ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ, ТӨРЛӨӨР**



2026 оны 4 дүгээр сарын байдлаар 1649 эхээс 1676 хүүхэд мэндэлсэн байна. Өнгөрсөн оны мөн үед 1715 эхээс 1724 хүүхэд мэндэлж байжээ. Тайлант хугацаанд 0-1 насны хүүхдийн эндэгдэл 22 гарсан нь өмнөх оны мөн үеээс 4 (15.4%) буурсан байна. 1-5 насны хүүхдийн эндэгдэл 3 гарсан нь өмнөх оны мөн үетэй адил байна.

**ХҮСНЭГТ 4. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ IV САРД**

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Эхний улирал			Зөрүү	
		2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	Тоо	Хувь
Амаржсан эхийн тоо	тоо	1 857	1 715	1 649	-66	-3.8
Амьд төрсөн хүүхэд	тоо	1 864	1 724	1 676	-48	-2.8
Нийт нас баралт	тоо	577	549	562	13	2.4
0-1 насны хүүхдийн эндэгдэл	тоо	24	26	22	-4	-15.4
1-5 насны хүүхдийн эндэгдэл	тоо	3	3	3	0	0.0
Төрөхийн улмаас эндсэн эх	тоо	2	0	1	1	0

Эмнэлгийн байгууллагууд 2026 оны 4 дүгээр сарын байдлаар 429804 хүн үзлэг хийсний 166273 (38.7%) нь урьдчилан сэргийлэх, 106312 (24.7%) нь гэрийн үзлэг байна.

Тайлант хугацаанд 162 эх шинээр жирэмсний хяналтад орсноос 5 (3.1%) нь цус багадалттай, 3 (1.9%) трихомоноз, 2 (1.2%) тэмбүү тус тус өвчлөл эерэг гарсан байна. Шинээр хяналтанд орсон жирэмсэн эхчүүдийн 158 (97.5%) нь

жирэмсний эхний 3 сартайдаа хяналтад орсон байна. 2026 оны 4 дүгээр сарын байдлаар артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт 51460 хүн хамрагдсанаас 30784 (59.8%) эмэгтэйчүүд байна. Үүнээс давтан үзлэгт 1148 (2.2%) нь хамрагдсан байна. Чихрийн шижин хэв шинж 2-ын эрт илрүүлгийн үзлэгт 32437 хүн хамрагдсанаас 19137 (59%) нь эмэгтэйчүүд байна. Тайлант хугацаанд эрт илрүүлгийн үзлэгт

хамрагдсан нийт хүний 15188 (59.2%) нь артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт, 8787 (34.2%) нь чихрийн шижин хэв шинж 2-ын эрт илрүүлгийн үзлэгт, 1688 (6.6%) нь элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт тус тус хамрагдсан байна.

Тайлант хугацаанд 0-5 насны 12667 хүүхдийн өсөлтийн үндсэн үзүүлэлтийг шалгахад 0-5 насны хүүхдүүдийн 17 (0.1%) нь туранхай, 23 (0.2%) нь тураалтай, 21 (0.2%) нь өсөлтийн хоцрогдолтой хүүхэд байсан байна. Амбулатороор үйлчлүүлсэн 0-5 насны 127 хүүхэд А амин дэм, 6224 хүүхэд Д амин дэм тус тус уусан байна.

### Ойлголт, тодорхойлолт:

#### Амьд төрөлт:

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

#### Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):

Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.


Эх үүсвэр: Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв




## ДҮҮРГИЙН ТӨСӨВ

### 2026 оны IV сар, тэрбум төгрөг


Арсгал



Төсвийн орлогын бүтэц



Татварын орлогын бүтэц



- Татварын орлого
- Татварын бус орлого

- Орлогын албан татвар
- Өмчийн татвар
- Бусад татвар



# ДҮҮРГИЙН ТӨСӨВ

**Төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 12.6 хувиар өслөө.**

Дүүргийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2026 оны IV сард 54814.8 (80.1%) сая төгрөгт хүрч төлөвлөснөөс 13618.2 (19.9%) сая төгрөгөөр дутуу бүрдсэн бол өмнөх оны мөн үеэс 6142.6 (12.6%) сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн нийт орлогын гүйцэтгэлийн 52858.3 (96.4%) сая төгрөгийг татварын орлого, 1956.5 (3.6%) сая төгрөгийг татварын бус орлого бүрдүүлжээ. Нийт татварын орлогод 43041.8

(81.4%) сая төгрөгийг орлогын албан татвар, 2321.5 (4.4%) сая төгрөгийг өмчийн татвар, 4918.8 (9.3%) сая төгрөгийг газрын төлбөр, 2576.2 (4.9%) сая төгрөгийг бусад төлбөр хураамж тус тус эзэлж байна. Тайлант оны татварын орлогын дүн өмнөх оны IV сараас 5794.0 сая төгрөгөөр буюу 12.3 хувиар өссөн байна.


## ХҮСНЭГТ 5. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2026 ОНЫ ЭХНИЙ IV САРД

Үзүүлэлт	Төсвийн орлого/сая.төг/				Өөрчлөлт Хувь
	2025 I-IV		2026 I-IV		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	60 407.4	48 672.2	68 433.0	54 814.8	-19.9
<b>1. Татварын орлого</b>	57 507.1	47 064.3	67 512.8	52 858.3	-21.7
1.1 Орлогын албан татвар	47 497.5	38 073.7	56 319.9	43 041.8	-23.6
1.1.1.Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	27 206.6	24 106.8	35 089.3	29 347.1	-16.4
1.1.2. Үйл ажиллагааны орлого	2750	2 616.1	3 437.5	3 093.0	-10.0
1.1.3. Хөрөнгийн орлого	4375	3 319.7	4 991.0	3 203.9	-35.8
1.1.4. Хөрөнгө борлуулсны орлого	2200	2 130.5	3 648.1	3 965.5	8.7
1.1.5. Хувь хүнээс суутгасан ОАТ	10 965.9	5 900.6	9 154.0	3 432.3	-62.5
1.2. Өмчийн татвар	1 117.1	1 983.6	3 097.3	2 321.5	-25.0
1.2.1. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1100	1 961.8	3 077.7	2 298.9	-25.3
1.2.2. Бууны албан татвар	15	15.5	15.6	17.2	10.3
1.2.3. Малын тоо толгойн албан татвар	2.1	6.3	4	5.4	35.0
1.3. Газрын төлбөр	6 134.7	4 584.3	5 358.6	4 918.8	-8.2
1.3.1.Газрын төлбөр	6 134.7	4 584.3	5 358.6	4 918.8	-8.2
1.4. Дотоодын бараа үйлчилгээний татвар	18.9	11.6	19.6	0.3	-98.5
1.4.1. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	18.9	11.6	19.6	0.3	-98.5
1.5. Бусад нийтлэг төлбөр хураамж	2 738.9	2 411.1	2 717.4	2 575.9	-5.2
1.5.1. Улсын тэмдэгтийн хураамж	859.4	177.1	137.2	153.4	11.8
1.5.2. Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1 875.9	2 223.2	2 573.7	2 413.6	-6.2
1.5.3 Ус рашаан ашигласны төлбөр	3.6	10.8	6.5	8.9	36.9
<b>2.Татварын бус орлого</b>	2 900.3	1 607.9	920.2	1 956.5	2.1*
2.1. Хүү, торгуулийн орлого	915.8	618.8	550.9	1 625.6	2,9*
2.2. Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	70.5	59.4	69.3	54.0	-22.1
2.3. Бусад орлого	1 914.0	929.7	300	276.9	-7.7

## ХҮСНЭГТ 6. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ, 2026 ОНЫ ЭХНИЙ IV САРД

Төсвийн орлого			Үүнээс:						
Бүгд	Биелэлт %	Зөрүү сая.төг	Татварын орлого			Татварын бус орлого			
			Бүгд	Биелэлт %	Зөрүү сая.т	Бүгд	Биелэлт %	Зөрүү сая.т	
Дүн	54 814.8	80.1	-13 618.2	52 858.3	78.3	-14 654.5	1 956.5	2.1*	1 074.7

## ЗУРАГ 2. ТӨСВИЙН ОРЛОГО, САРААР



Энэ оны IV сард төсвийн орлогын төлөвлөгөө 18383.7 сая төгрөг, гүйцэтгэл 18643.8 сая төгрөгт хүрч сарын гүйцэтгэл 1.4

хувиар давж биелсэн байна. Энэ нь өнгөрсөн оны IV сараас төсвийн орлогын төлөвлөгөө 31.3 хувиар, гүйцэтгэл 36.9 хувиар өсжээ.


## ХҮСНЭГТ 7. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2026 ОНЫ ЭХНИЙ IV САРД

Үзүүлэлт	Батлагдсан төсөв жилээр	Төсвийн зарлага/сая.төг/ 2026 I-IV		Хувь
		Төсөв	Гүйцэтгэл	
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	223 048.1	60 700.8	53 327.4	87.9
Урсгал зардал	174 097.2	54 395.4	47 021.9	86.4
Бараа, ажил үйлчилгээний зардал	160 406.4	49 848.1	42 587.8	85.4
Урсгал шилжүүлэг	13 690.8	4 547.3	4 434.1	97.5
Хөрөнгийн зардал	48 950.9	6 305.5	6 305.5	100.0

Мэдээллийн эх үүсвэр: Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс

Дүүргийн оны эхний IV сарын төсвийн зарлага 53327.4 сая төгрөг бөгөөд нийт батлагдсан төсвийн 27.2%-ийг эзэлж байна. Үүнээс 87.9 хувь буюу 53327.4 сая төгрөгийг зарцуулжээ. Энэ сарын зарцуулсан зардлын 86.4 хувийг урсгал шилжүүлгийн зардал, 12.1 хувийг хөрөнгийн зардалд зарцуулжээ.

### ЗУРАГ 3. ТӨСВИЙН ЗАРЛАГА, ОНЫ ЭХНИЙ IV САРААР



2026 оны эхний IV сарын төсвийн төлөвлөсөн зардал өмнөх оны мөнх үеэс 12491.6 (17.1%) сая төгрөгөөр буурсан бол гүйцэтгэл 5587.3 (11.7%) сая төгрөгөөр өссөн байна.

#### Ойлголт, тодорхойлолт:

##### Татварын орлого:

Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

##### Төсвийн зарлагын ангилал:

Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

##### Урсгал зардал:

Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

##### Татварын бус орлого:

Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

##### Төсвийн орлого:

Тогтворжуулалтын сан, ирээдүйн өв сан, хуримтлалын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

##### Улсын төсөв:

Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Эх үүсвэр: Сонгинохайрхан дүүргийн Засаг Даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс.



# НИЙГМИЙН ДААТГАЛ

**Нийгмийн даатгалын сангийн орлогын гүйцэтгэл оны эхний IV сард 1.8%-иар давж биелсэн байна.**

Нийгмийн даатгалын шимтгэлийн нийт орлогын төлөвлөгөө 2026 оны эхний IV сард 82.8 тэрбум, гүйцэтгэл 84.2 тэрбум төгрөгт хүрч биелсэн байна. Үүний 83.4%-ийг тэтгэврийн


даатгал, 8.9%-ийг тэтгэмжийн даатгал, 4.7%-ийг ҮОМШӨ-ний даатгал, 3.0%-ийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна

## ХҮСНЭГТ 8. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, 2026 ОНЫ IV САРД

Үзүүлэлт	2026 I-IV	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	сая төгрөг	
<b>Нийт орлого</b>	<b>82 755.6</b>	<b>84 225.4</b>
Тэтгэврийн даатгалын сан	68 380.0	70 251.5
Тэтгэмжийн даатгалын сан	7 332.5	7 496.0
ҮОМШӨ <sup>1</sup> -ний даатгалын сан	4 514.0	3 937.4
Ажилгүйдлийн даатгалын сан	2 529.1	2 540.5

ҮОМШӨ<sup>1</sup>-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

## ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ХУВИАР



Нийгмийн даатгалын сангаас 2026 оны IV сард 199.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг 53457 хүнд олгожээ. Үүний 176.1 (88.1%) тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас, 10.8 (5.4%) тэрбум төгрөгийг тэтгэмжийн даатгалын сангаас, 1.2 (0.6%) тэрбум төгрөгийг ҮОМШӨ-ний даатгалын сангаас, 11.8 (5.9%) сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангаас тус тус олгосон байна. Тэтгэврийн


даатгалын сангийн 79.0%-ийг өндөр насны тэтгэвэр, 9.1%-ийг Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэвэр, 3.1%-ийг Тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 8.9%-ийг Цэргийн албан хаагчийн тэтгэвэр болон бусад зардал эзэлж байна.

### ХҮСНЭГТ 9. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ

	Үзүүлэлт	Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо	2026 I-IV	
			Төлөвлөгөө сая төгрөг	Гүйцэтгэл
	Нийт олгосон тэтгэвэр, тэтгэмж	53 457	198 121.7	199 899.9
1	Тэтгэврийн даатгалын сан	46 851	173 766.1	176 066.0
	1.1.Өндөр насны тэтгэвэр	36 788	138 191.3	139 068.8
	1.2.Хөдөлмөрийн чадвар алдсны тэтгэвэр	5 673	15 396.3	15 978.4
	1.3.Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	1 868	4 833.6	5 403.0
	1.4.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр	2 522	15 223.8	15 603.9
	1.5.Бусад зардал	-	21.1	11.8
2	Тэтгэмжийн даатгалын сан	4 221	11245.9	10 845.7
	2.1.ХЧТА тэтгэмж	2 077	1068.22	1 123.9
	2.2.Жирэмсний болон амаржсаны	1 654	8235.7	8 169.8
	2.3.Нас барсан даатгуулагчийн гэр бүлд олгох тэтгэмж	490	1719.6	1 461.0
	2.4.Бусад зардал	-	222.3	91.0
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	287	1306.3	1 205.2
	3.1.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	214	1012.2	925.2
	3.2.Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	37	148.1	175.1
	3.3.ҮОМШӨ тэтгэмж	36	68.2	75.1
	3.4.ҮОМШӨ сувиллын зардал	-	19.9	0.1
	3.5.Бусад зардал	1	57.9	29.8
4	Ажилгүйдлийн даатгалын сан	2 098	11 803.4	11 783.0
	4.1.Ажилгүйдлийн тэтгэмж	2 098	11803.3	11 782.9
	4.2.Бусад зардал	-	0.1	0.1

Мэдээллийн эх үүсвэр: Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газар

### ЗУРАГ 5. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧДЫН ТОО, ОНЫ ЭХНИЙ IV САРД



**Ойлголт, тодорхойлолт:**

**Нийгмийн даатгал:**

Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

**Тэтгэмж:**

Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна. Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наадзахын хэрэгцээг нь хангах зорилгоор

**Эх үүсвэр:**

Дүүргийн Нийгмийн даатгалын газар

улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

**Нийгмийн даатгалын сан:**

Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

**Тэтгэвэр:**

Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

**Даатгуулагч:**

Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.



# НИЙГМИЙН ХАЛАМЖ

**Сонгинохайрхан дүүрэгт Нийгмийн халамжийн зарлага 2026 оны эхний IV сард 93.4 сая төгрөгт хүрсэн байна.**

Нийгмийн халамж нь орлого багатай, хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэршээлтэй иргэн зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн төрөөс иргэдээ дэмжих арга хэрэгсэл юм.

Сонгинохайрхан дүүргийн нийгмийн халамжийн сангаас 2026 оны эхний 4 сард 677.0 мянган хүнд 93439.8 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж олгогдсон байна.

## ХҮСНЭГТ 10. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр, оны эхний IV сард

Үзүүлэлт	2026 I-IV		Нийт халамжийн санд эзлэх хувь
	Хүн	Гүйцэтгэл	
	Тоо	Сая төгрөг	
<b>Нийт</b>	<b>676 988</b>	<b>93 439.8</b>	<b>100</b>
Нийгмийн халамжийн тэтгэвэр	26 239	12 224.9	13.1
Асаргааны тэтгэмж	26 686	9 264.4	9.9
Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	41 644	3 015.1	3.2
Алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж	15	5 322	5.7
Хүүхдийн мөнгө	529 841	52 680.1	56.4
Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж	31	37.2	0.04
Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	6 705	2 818.6	3.02
Ахмад настны хөнгөлөлт, тусламж	2 078	531.7	0.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж	2 036	441.1	0.5
Алдарт эхийн одон	23 478	5 623.8	6.02
Насны хишиг	18 235	1 480.9	1.52

Олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн 52680.1 (56.4%) сая төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмж, 12224.9 (13.1%) сая төгрөгийг нийгмийн халамжийн тэтгэвэр, 9264.4 (9.9%) сая төгрөгийг асаргааны тэтгэмж, 5623.8 (6.02%) сая төгрөгийг алдарт эхийн одонгийн тэтгэмж, 5322 (5.7) сая төгрөгийг алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж, 3015.1 (3.2%) сая төгрөгийг эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж, 2818.6 (3.02%) сая төгрөгийг амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 1480.9 (2.146%) сая төгрөгийг насны хишигийн тэтгэмж, үлдсэн 1010 (1.14%) сая төгрөгийг онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж, ахмад настны хөнгөлөлт, тусламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж тус тус эзэлж байна.

## ХҮСНЭГТ 11. АХМАД НАСТНЫ ТЭТГЭМЖ, ХӨНГӨЛӨЛТ, төрлөөр, оны эхний IV сард

Үзүүлэлт	2026 I-IV		Нийт ахмад настны тэтгэмж, хөнгөлөлтөнд эзлэх хувь
	Хүн	Гүйцэтгэл	
	Тоо	Сая төгрөг	
<b>Нийт</b>	<b>2 078</b>	<b>531.7</b>	<b>100</b>
Оршуулгын тэтгэмж	44	115.0	21.6
Рашаан сувилал	74	18.7	3.5
Протез	664	173.6	32.6
Ортопед, тусгай хэрэгсэл	1 110	145.6	27.5

“Дүүргийн нийгэм, эдийн засгийн байдал” 2026 оны IV сарын танилцуулга

Ахмад настны тэтгэмж, хөнгөлөлтийн 173.6 (32.6%) сая төгрөгийг рашаан сувилалд амрах хөнгөлөлт, 145.6 (27.5) сая төгрөгийг протез /Сүүж-түнхний үе, өвдөгний үе, сүүж-түнх, дунд чөмөг, шилбэ, шилбэний түгжээт хадаас, өвдөгний тулгууртай шилбэний, тавхай, тавхайн урд хэсэг, мөр, бугалга, тохой, шуу, сарвуу, хуруу, хиймэл шүд, эрүү, зүрхний хиймэл

хавхлага, гавлын титан бүрхэвч, дунд чихний титан, шилэн нүд, хуванцар нүд, нүдний болор, нүдний уян болор зэргийг суулгах/-ийн хөнгөлөлт, 115 (21.6%) сая төгрөгийг оршуулгын тэтгэмж, 78.8 (14.8%) сая төгрөгийг ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлт, 18.7 (3.5%) сая төгрөгийг амралт сувиллын хөнгөлөлт тус тус эзэлж байна.

**ХҮСНЭГТ 12.**

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨНГӨЛӨЛТ, тусламж, төрлөөр, оны эхний IV сард**

Үзүүлэлт	2026 I-IV		Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжинд эзлэх хувь
	Хүн	Гүйцэтгэл	
	Тоо	Сая төгрөг	
<b>Нийт</b>	<b>2 036</b>	<b>441.1</b>	<b>100</b>
Оршуулгын тэтгэмж	48	148.0	33.5
Харилцаа, холбооны зардал	964	20.8	4.7
Рашаан сувилал	41	15.0	3.4
Цэцэрлэг, сургуулийн унааны хөнгөлөлт	178	35.6	8.1
Ортопед, тусгай хэрэгсэл	325	141.1	32.0
Протез	175	37.9	8.7
Түлш, орон сууцны үнийн хөнгөлөлт	305	42.7	9.6

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжийн 148.0 (33.5%) сая төгрөгийг оршуулгын тусламж, 141.1 (32.0%) сая төгрөгийг ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлт, 42.7 (9.6%) сая төгрөгийг түлш, орон сууцны үнийн хөнгөлөлт, 37.9 (8.7%) сая төгрөгийг протез /Сүүж-түнхний үе, өвдөгний үе, сүүж-түнх, дунд чөмөг, шилбэ, шилбэний түгжээт хадаас, өвдөгний тулгууртай шилбэний, тавхай, тавхайн урд хэсэг, мөр, бугалга, тохой, шуу, сарвуу, хуруу,

хиймэл шүд, эрүү, зүрхний хиймэл хавхлага, гавлын титан бүрхэвч, дунд чихний титан, шилэн нүд, хуванцар нүд, нүдний болор, нүдний уян болор зэргийг суулгах/-ийн хөнгөлөлт, 35.6 (8.1%) сая төгрөгийг цэцэрлэг сургуулийн унааны хөнгөлөлт, 20.8 (4.7%) сая төгрөгийг харилцаа, холбооны зардал, 15.0 (3.4%) сая төгрөгийг рашаан сувиллын хөнгөлөлт, тус тус эзэлж байна.

## Ойлголт, тодорхойлолт:

### Нийгмийн халамж:

Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

### Байнгын асаргаа шаардлагатай иргэн:

Бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны

хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнийг хэлнэ.

### Бүтэн өнчин хүүхэд:

Эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ

амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх/эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг хэлнэ.

### Өрх толгойлсон эх /эцэг/:

Нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг хэлнэ.

### Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ:

Асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагаа хэлнэ.


Эх үүсвэр: Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн халамжийн хэлтэс



## ГЭМТ ХЭРЭГ

2026 оны эхний IV сард

ᠮᠣᠩᠭᠡᠨ  
ᠨᠢᠶ᠋ᠢᠨ




Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

2025 IV  
1 770

2026 IV  
**1 953** 10.3% ↑

Дүүргээр



Гэмт хэргийн улмаас



Хохирсон хүн  
1 749



Гэмтсэн хүн  
341



Нас барсан хүн  
70



## ГЭМТ ХЭРЭГ

**Сонгинохайрхан дүүрэгт 2026 оны IV сард 1956 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 183 (10.3%) хэргээр өссөн байна.**

Монгол улсад 2026 оны эхний 4 сард нийт 19875 гэмт хэрэг бүртгэгдсэнээс нийслэлд 13818 (69.5%), дүүрэгт 1953 (9.8%) гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй

харьцуулахад улсын хэмжээнд 1213 (6.8%), нийслэлийн хэмжээнд 699 (5.3%), дүүргийн хэмжээнд 183 (10.3%) хэргээр тус тус өссөн байна.

### ХҮСНЭГТ 13. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хэлтсээр, оны эхний IV сард

Хэлтэс	2025 I-IV		2026 I-IV		Өөрчлөлт		Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
	Тоо		Тоо		Тоо	Хувь	
Нийт гэмт хэрэг	1097	956	-141	-12.8	100.0		
СХДЦХ-1	510	377	-133	-26.1	39.4		
СХДЦХ-2	301	304	3	1.0	31.8		
СХДЦХ-3	286	275	-11	-3.8	28.8		

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Цагдаагийн 2 дүгээр хэлтэст 273 (61.1%), Цагдаагийн 3 дугаар

хэлтэст 63 (14.1%) хэргээр тус тус өссөн бол Цагдаагийн 2 дугаар хэлтэст 153 (17.4%) хэргээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.

### ХҮСНЭГТ 14. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, оны эхний IV сард


Төрөл	2025 I-IV		2026 I-IV		Өөрчлөлт		Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
	Тоо		Тоо		Тоо	Хувь	
Нийт гэмт хэрэг	1 770	1 953	183	10.3	100.0		
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	49	51	3	6.1	2.5		
Хүнийг алах гэмт хэрэг	6	9	3	50	0.4		
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	379	323	-54	-14.2	16.4		
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхгэмт хэрэг	8	4	-4	-50	0.2		
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	27	38	11	40.7	1.8		
Хүчиндэх гэмт хэрэг	14	12	-2	14.3	0.6		
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	20	2	-18	-90.0	0.1		
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	2	2	-	-	0.1		
Хулгайлах гэмт хэрэг	433	411	-22	-5.1	21.0		
Дээрэмдэх гэмт хэрэг	81	61	-30	-37.0	3.0		
Залилах гэмт хэрэг	455	712	257	56.5	36.4		
Хөрөнгө завших гэмт хэрэг	32	22	-10	-31.2	1.1		
Алдаатай гүйлгээ андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэрэг	49	59	10	20.4	2.9		
Автотээврийн хэрэгсэл зөвшөөрөлгүй авч явах	9	10	1	11.1	0.5		
Эд хөрөнгө устгах, гэмтээх	33	41	8	24.2	1.9		
Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	10	38	28	3.8**	1.8		
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	14	29	15	2.1**	1.4		
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	8	7	-1	-12.5	0.3		
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	7	7	-	-	0.3		
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	20	41	21	2**	2.0		

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	114	103	-11	-9.6	5.2
--	-----	-----	-----	------	-----

